

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ӨГӨГДӨЛ

Бат нь 2019 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2 дугаар зүйлийн 3 дах хэсгийн 3.1 дэх заалтад зааснаар 6 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгүүлж, 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр шүүгчийн захирамжаар 2 жил 8 сарын хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдаж, мөн хугацаагаар хяналт тогтоогдсон байв. Тэр цаг үеэс хойш Бат нь ах Доржийн портер маркийн 77-27 УБД улсын дугаартай тээврийн хэрэгслийг түр ашиглаж, хувиараа ажилласан, улмаар 2023 оны 1 дүгээр сард Булган аймаг руу явж, тэнд барилгын ажил хийж байхдаа хуучны танил бөгөөд эр, эмийн харилцаатай байсан Сувдтай таарч, түүний гэрт очдог болжээ. Бат нь эр, эмийн харьцаагаа сэргээхийг хүсэж, улмаар согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн байхдаа буюу 2023 оны 6 дугаар сарын 30-ний өдөр Булган аймгийн төвөөс холгүй зайд байх Сувдын зуслангийн гэрт очиж, авч очсон согтууруулах ундааны зүйлсээс хэрэглэж, хонохоор шийджээ. Ингээд 23 цагийн орчим эр, эмийн харилцаанд орохоор Сувдыг оролдох, ятгах явцад Сувд эрс эсэргүүцэж улмаар “урьдын харилцаа одоо байхгүй” гэж хэлээд өөрийн 10 настай хүү Дөлгөөн, 15 настай охин Чимгээ хоёрын хамт аймгийн төв орохоор мотоциклтой явжээ. Бат нь үүнд нь уурлаж, тухайн тээврийн хэрэгслээ унаж Сувдын араас хөөж, мөргөж унагаан улмаар хэргийн газраас зугтааж Улаанбаатар хот руу явсан. Уг ослын улмаас Сувдын биед гавал тархины хүнд гэмтэл учирч, Дөлгөөний амь нас хохирч, Чимгээгийн биед хөнгөн хохирол учирсан. Хэргийн баримтаар:

77-27 УБД улсын дугаартай, 5 сая төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгслийн эзэмшигч Доржийг иргэний хариуцагчаар татсан, Сувд гэмт хэргийн улмаас эмчилгээний зардалд 13 сая төгрөг, оршуулгын зардалд 8 сая төгрөг, мотоциклд учирсан хохиролд 2 сая төгрөгийг холбогдох баримтаар, мөн өөрт учирсан хүнд гэмтэл болон хүү Дөлгөөн нас барсны улмаас өөрийн сэтгэцэд учирсан хохирлуудыг нэхэмжилсэн. Прокуророос Батад холбогдох хэргийг 2024 оны 1 дүгээр сард шүүхэд шилжүүлсэн, шүүх хуралдаанд Батын өмгөөлөгч “...мөрдөн байцаалтын шатанд насанд хүрээгүй хохирогч Чимгээгээс мэдүүлэг авахдаа өмгөөлөгч оролцуулаагүй учир хэргийн эцэслэн шийдвэрлэх боломжгүй. Иймд хэргийг прокурорт буцааж өгнө үү...” гэсэн хүсэлтийг гаргасан.

Шийдвэрлэх асуудал:Бодлогын нөхцөлийн хүрээнд шийдвэрлэвэл зохих бүхий л асуудалд хууль зүйн дүгнэлт хийнэ үү.

БОДОЛТ

1. Хууль зүйн дүгнэлт хийх хэм хэмжээг тодорхойлох.

Бодлогын нөхцөлөөс Бат нь хүний амьд явах эрхийн эсрэг, мөн хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг үйлдэл хийсэн гэж үзэхээр байх тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10 дугаар болон 12 дугаар бүлгээс холбогдох хэм хэмжээг сонгон авч байна. Тодруулбал,

1. Бат нь эр эмийн харилцаанд орохоор Сувдыг оролдож, ятгасан үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлд,

2. Бат нь Сувдыг хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын хамт мотоциклтой явж байхад араас нь тээврийн хэрэгслээр хөөж мөргөн унагааснаар:

- нэг хүнийг алсан үйлдлийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйл,

- 2 хүнийг алахаар завдсан үйлдлийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан мөн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлд тус тус зохицуулсан гэж үзэхээр байна.

2. Сонгож авсан хэм хэмжээ болон түүний хууль зүйн шинжийг тодорхойлж бодлогын нөхцөлтэй субсумци хийх

2.1. Бат нь эр эмийн харилцаанд орохоор Сувдыг оролдож, ятгасан үйлдлийн талаар:

Объектив тал:

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хүчиндэх гэмт хэргийн объектив тал нь “хохирогчийн хүсэл зоригийн эсрэг хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл...бусад өвчний улмаас биеэ хамгаалах, эсэргүүцэл үзүүлэх чадваргүй, эсхүл эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгааг далимдуулан хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл хийсэн” байхыг шаардана.

Гэтэл Батын хувьд Сувтай эр, эмийн харилцаанд орохоор оролдож, ятгасан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт хүчиндэх гэмт хэргийн объектив талын шинжийг хангахгүй буюу хүчиндэх гэмт хэргийн үйлдэлд тооцогдох үндэслэлгүй байх тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Эрүүгийн хуулийг төсөөтэй хэрэглэхгүй.

Субъектив тал:

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүчиндэх гэмт хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ.

Гэм буруугийн санаатай хэлбэр гэж Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “Өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүнийг хүсэж үйлдсэн, хохирол хор уршигт зориуд хүргэсэн” байхыг хэлнэ.

Өөрөөр хэлбэл, субъект нь өөрийн үйлдлийг хууль бус болохыг ухамсарлаж буюу мэдэх, түүний улмаас үүсэх үр дагаврыг хүсэх гэсэн оюун санааны элементүүдийг агуулсан байх ёстой.

Гэтэл Бат нь хүчиндэх гэмт хэргийн объектив талд хамаарах үйлдэл хийгээгүй байх тул гэм буруугийн асуудал байхгүй гэж үзнэ.

Бат зөвхөн урьд эр, эмийн харилцаатай байсан Сувдтай дахин эр, эмийн харилцаанд орох зорилготой байсан нь түүний үзэл бодлын шинж агуулсан санаа байх тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар хүний үзэл бодлын төлөө эрүүгийн

хариуцлага хүлээлгэхгүй. Өөрөөр хэлбэл, гэм буруугийн ухамсар байхгүй бол гэм буруутай гэж үзэхгүй.

Иймд Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 1.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар “Бат нь Сувтай эр, эмийн харилцаанд орохоор оролдож, ятгасан үйлдэл” нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг биш болно. Тодруулбал, “Nullum crimen nullum poena sine lege” буюу хуулийг чанд сахих зарчим үйлчилнэ.

Тийм учраас Батын хийсэн эр эмийн харилцаанд орохоор Сувдыг оролдож, ятгасан үйлдэл нь гэмт хэргийн шинжийг хангахгүй тул цаашид үргэлжлүүлэн шалгах шаардлагагүй гэж дүгнэж байна.

2.2. Бат нь Сувдыг хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын хамт мотоциклтой явж байхад араас нь тээврийн хэрэгслээр хөөж мөргөн 1 хүнийг алсан болон 2 хүнийг алахаар завдсан үйлдлийн талаар:

Бат нь Сувдыг хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын хамт мотоциклтой явж байхад араас нь тээврийн хэрэгслээр хөөж мөргөн унагаасан үйлдэл нь хүний амь нас буюу эрүүл мэндэд хохирол учруулахад чиглэсэн хууль бус, нийгэмд аюултай үйлдэл хийсэн гэж үзнэ. Учир нь, аливаа тээврийн хэрэгсэл, түүнийг жолоодон үйлдэл хийх нь орчинд тойрондоо буюу хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул учруулах хэрэгсэл, үйл ажиллагаанд тооцогддог.

Бат нь Сувд, Дөлгөөн, Чимгээ нарын амь нас буюу эрүүл мэндэд аюул учруулахад чиглэсэн нэг удаагийн буюу тэднийг мотоциклтой явж байхад араас нь тээврийн хэрэгслээр хөөж мөргөсөн үйлдлийн улмаас 1 хүн амь насаа алдаж, харин Батын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас 2 хүний амь нас эрсдээгүй байх тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар нэг удаагийн үйлдлээр хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэнд тооцох үндэслэлтэй. Учир нь, хүн тус бүрийн амь нас, эрүүл мэнд тус бүртээ Эрүүгийн хуулиар хамгаалагдсан хамгийн чухал үнэт зүйлс бөгөөд нэг хүний амь нас, эрүүл мэндийн хохирлыг бусад хүний амь нас, эрүүл мэндийн хүнд хохирол, хор уршигт нь багтаах буюу хүнийг алах болон алахаар завдсан үйлдлийг адилтгах, төсөөтэй хэрэглэх, нэгтгэх байдлаар зүйлчлэх үндэслэлгүй юм.

Тийм учраас Батын “Сувдтай эр, эмийн харилцаанд орж чадаагүйдээ уурлаж, Сувдыг хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын хамт мотоциклтой явж байхад араас нь тээврийн хэрэгслээр хөөж, мөргөн унагааж 1 хүнийг алсан болон 2 хүнийг алахаар завдсан үйлдэл”-ийг нэгэн зэрэг шалгах нь зүйтэй.

Объектив тал:

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг нь материаллаг бүрэлдэхүүнтэй хэм хэмжээ учраас үйлдэл ба амь насаа алдсан хохирлын хооронд шалтгаант холбоо байхыг шаардана.

Хэрэв хүнийг алахад чиглэсэн үйлдэл хийсэн боловч хохирогч амь насаа алдаагүй бол Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “гэмт хэрэг үйлдэхэд шууд чиглэсэн үйлдэл, эс үйлдэхүйг санаатай хийсэн боловч тухайн хүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас гэмт хэрэг төгсөөгүй бол” гэмт хэрэг үйлдэхээр завдах үйлдэлд тооцохоор хуульчилсан.

Бодлогын нөхцөлөөр: Бат нь Сувдтай эр, эмийн харилцаанд орж чадаагүйдээ уурлаж, Сувдыг хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын хамт мотоциклтой явж байхад нь орчиндоо аюултай тээврийн хэрэгсэл жолоодон араас нь хөөж, мөргөсний улмаас 10 настай Дөлгөөний амь нас

хохирсон байх тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн объектив талын шинжийг хангаж байна.

Харин тухайн мотоциклтой явж байсан Сувд, түүний хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын араас тээврийн хэрэгслээр хөөж, тэдгээрийг мөргөж унагаах аргаар тэдний амь нас буюу эрүүл мэндэд аюул учруулахад чиглэсэн үйлдэл хийсэн байх боловч түүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас Сувд, түүний охин Чимгээ нар нас бараагүй байх тул хүнийг алах гэмт хэрэг үйлдэхээр завдсан шинжийг хангаж байна.

Иймд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу Батын үйлдсэн “Сувд, түүний охин Чимгээ нарыг алахаар завдсан” гэмт хэргийн объектив талын шинж хангагдсан гэж үзнэ.

Тийм учраас Батын дээрх аюултай үйлдлийн улмаас Сувдын эрүүл мэндэд хүнд хохирол, Чимгээгийн эрүүл мэндэд хөнгөн хохирол учирсан байх нь Батад холбогдох “хүнийг алах болон хүнийг алахаар завдсан нийлмэл үйлдлийн шинж”-ийг үгүйсгэх үндэслэл биш болно.

Мөн Бат нь Сувдыг хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын хамт мотоциклтой явж байхад нь орчиндоо аюултай тээврийн хэрэгсэл жолоодон араас нь хөөж, мөргөж унагаан улмаар зугтаасан нь Сувдтай эр, эмийн харилцаанд орж чадаагүйдээ уурлаж, тэдний амь нас буюу эрүүл мэндэд аюултай хохирол учруулахад чиглэсэн санаатай үйлдлийн шинжийг бүрэн хангасан байх тул Эрүүгийн хуулийн 27.10, 27.11 дүгээр зүйлд заасан “тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих болон авто тээврийн гэмт хэрэг үйлдсэн жолооч зугтаах” үйлдлийн шинжтэй адилтгах үндэслэлгүй, төсөөтэй шинжгүй гэж үзнэ.

Учир нь, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн хувьд жолооч нь өөр бусад сэдэлт, зорилгогүйгээр зөвхөн замын хөдөлгөөнд тээврийн хэрэгсэл жолоодон оролцох үедээ хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмыг зөрчихгүй, ямарваа зөрчил гаргахгүй байж чадна гэж тооцсон үйлдэл хийсэн байдаг ба хэрэв хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөн үйлдэл нь тухайн гэмт хэргийн шинжийг хангасан байхад зугтаасан бол Эрүүгийн хуулийн 27.10, 27.1 дүгээр зүйлд заасан дээрх гэмт хэргийн объектив талын шинж хангагдсанд тооцдог.

Субъектив тал:

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэм хэрэг нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ.

Гэм буруугийн санаатай хэлбэр гэдэг нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “өөрийн үйлдэл, эс үйлдэхгүйг хууль бус шинжтэй болохыг ухамсарлаж түүнийг хүсэж үйлдсэн, хохирол хор уршигт зориуд хүргэсэн” байхыг хэлнэ.

Бодлогын нөхцөлд Бат нь согтуурсан үедээ Сувдтай эр, эмийн харилцаанд орж чадаагүйдээ уурлаж, улмаар мотоциклтой явж байсан Сувд, түүний хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын араас тэдний амь нас, эрүүл мэндэд аюултай аргаар буюу автомашин жолоодон хөөж, мөргөж унагааж буй үйлдэл нь гэмт санааны агуулга, чиглэлийн хувьд гэм буруугийн санаатай хэлбэрийн шинжийг хангаж байх бөгөөд Бат нь өөрийн сонгож авсан арга буюу тээврийн хэрэгслээр хөөж мөргөсөн үйлдлээр тухайн хүмүүсийн амь насанд аюултай гэдийг бүрэн ухамсарлаж байсан гэж үзнэ.

Мөн Бат нь тийнхүү автомашинаар хөөж, мөргөж унагаасан даруйд зугтааж явсан нь түүний үйлдсэн хэргийн гэм буруугийн санаатай хэлбэрийн утга агуулгыг давхар илэрхийлж байна. Тийм учраас, Бат нь тээврийн хэрэгслээр хөөж мөргөхөд Сувдын эрүүл мэндэд хүнд хохирол, 15 настай Чимгээгийн эрүүл мэндэд хөнгөн хохирол учирсан байх нь Батын үйлдсэн хүнийг алах гэмт хэргийн субъектив талын шинжийг үгүйсгэх үндэслэлд хамаарахгүй юм.

Хүнийг алах гэмт хэргийн хүндрүүлэх шинж:

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт тус гэмт хэргийн хүндрүүлэх болон онц хүндрүүлэх шинжийг хуульчилсан.

Бат нь тээврийн хэрэгслээр Сувдыг хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын хамтаар мотоциклтой явж байхад араас нь хөөж мөргөн 10 настай буюу бага насны хүүхэд болох Дөлгөөнийг алсан гэмт хэргийн хувьд гэмт хэрэг үйлдэгдэх үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7 дахь заалтад заасан”...бага насны хүүхэд болохыг мэдсээр байж...” гэх шинжийг хангаж байна.

Учир нь, Дөлгөөн нь 10 настай буюу бага насны хүүхэд байх бөгөөд бодлогын нөхцөлд өгөгдсөнөөр Бат нь Сувдын гэрээр ордог болсон байх тул Дөлгөөнийг бага насны хүүхэд болохыг мэдэж байсан гэж үзнэ.

Харин Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн хуулиар: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7 дахь заалт дахь ”...бага насны хүүхэд болохыг мэдсээр байж...” гэх шинжийг мөн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн онц хүндрүүлэх бүрэлдэхүүнээр хуульчлан тогтоосон буюу ”...бага насны хүүхдийг алсан бол 12-25 жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ” гэж нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар буюу гэмт хэрэг үйлдэх үед дагаж мөрдөж байсан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7 дахь заалтад заасан”...бага насны хүүхэд болохыг мэдсээр байж...” алсан бол 12-20 жил хүртэл хугацаагаар хорих эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэхээр байна.

Тухайн тохиолдолд Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх үндэслэл, журмыг шалгах ба Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт шинээр тооцсон, оногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй” гэж заасан.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7 дахь заалт болон 10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан ялын хэмжээг харьцуулахад сүүлд нэмэлт өөрчлөлт оруулсан ялын хэмжээ нь Батын эрх зүйн байдлыг дордуулахаар байх тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар мөн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан хэм хэмжээг буцаан хэрэглэх боломжгүй юм.

Иймд Батын “тээврийн хэрэгслээр Сувдыг хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын хамтаар мотоциклтой явж байхад араас нь хөөж мөргөн 10 настай буюу бага насны хүүхэд болох Дөлгөөнийг алсан үйлдэл” нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7 дахь хэсэгт заасан хүндрүүлэх шинжийг хангаж байна.

Мөн Бат 77-27 УБД улсын дугаартай тээврийн хэрэгслээр Сувдыг хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын хамтаар мотоциклтой явж байхад араас нь хөөж мөргөн алахад чиглэсэн үйлдэл хийсэн байх боловч түүний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас Сувд, Чимгээ нарын амь нас хохироогүй буюу алахыг завдсан гэмт хэргийн хувьд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.6 дахь заалтад “хоёр...хүнийг” гэсэн хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжийг хангасан байна.

Учир нь, Бат нь Сувдыг хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын хамт мотоциклтой явж байхад араас нь тээврийн хэрэгслээр хөөж мөргөн унагааж, хүнийг алахад чиглэсэн хууль бус, нийгэмд аюултай үйлдлийн улмаас Дөлгөөн амь нас барж, харин Батын хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлын улмаас Сувдаа, Чимгээ нар амь насаа алдаагүй байх тул 2 хүнийг алахаар завдсан гэж үзнэ.

Иймд Батын үйлдсэн “Сувдыг хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын хамт мотоциклтой явж байхад араас нь тээврийн хэрэгслээр хөөж мөргөн 15 настай Дөлгөөнийг алсан гэм буруутай үйлдэл”-ийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.8 дугаар зүйлийн 1, 1.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7 дахь заалтад зааснаар, харин Батын үйлдсэн “Сувдыг хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын хамт мотоциклтой явж байхад араас нь тээврийн хэрэгслээр хөөж мөргөн Сувд, 15 настай Чимгээ нарыг алахаар завдсан гэм буруутай үйлдэл”-ийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан мөн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.6 дахь заалтад тус тус зааснаар зүйлчлэн шийдвэрлэх үндэслэлтэй гэж дүгнэж байна.

Харин тухайн тохиолдолд хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 11.1 болон 11.6 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт дангаар эсхүл давхар зүйлчлэх үндэслэлгүй болно.

3. Гэмт хэрэг үйлдэх үе шатыг тогтоох.

Эрүүгийн эрх зүйд гэмт хэрэгт бэлтгэх болон завдахыг төгсөөгүй гэмт хэрэг гэж үздэг ба урьдчилсан нөхцөл нь үйлдэл туйлдаа хүрч эрүүгийн хуулиар шаардсан үр дүн гаргаагүй байх явдал юм.

Бат нь Сувдыг хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын хамт мотоциклтой явж байхад араас нь тээврийн хэрэгслээр хөөж мөргөн 15 настай Дөлгөөнийг алсан гэм буруутай үйлдлийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.8 дугаар зүйлийн 1, 1.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.6 дахь заалтад зааснаар зүйлчилсэн тул тухайн гэмт хэрэгт завдсан асуудал яригдахгүй.

Харин Бат нь Сувдыг хүү Дөлгөөн, охин Чимгээ нарын хамт мотоциклтой явж байхад араас нь тээврийн хэрэгслээр хөөж мөргөн Сувд, 15 настай Чимгээ нарыг алахаар завдсан гэм буруутай үйлдлийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан мөн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.6 дахь заалтад тус тус зааснаар зүйлчлэн шийдвэрлэх үндэслэлтэй гэж өмнө дүгнэсэн, харин тухайн гэмт хэрэгт бэлтгэсэн нөхцөл байдал байгаагүй болно.

4. Гэмт хэрэгт хамтран оролцох төрөл, хэлбэр байгаа эсэхийг тогтоох.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хоёр, түүнээс олон хүн гэмт хэрэг үйлдэхэд санаатай нэгдсэнийг гэмт хэрэгт хамтран оролцох гэнэ” гэж заасан.

Тус хэм хэмжээний урьдчилсан нөхцөлд хоёр буюу түүнээс олон хүн, гэмт хэрэг үйлдэхэд санаатай нэгдсэн гэсэн хоёр хууль зүйн нөхцөл байдаг.

Бодлогын нөхцөлөөс үзэхэд Бат нь хүнийг алах болон хүнийг алахаар завдсан дээрх гэмт хэргийг дангаараа үйлдсэн байх тул гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэр байхгүй.

5. Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдал.

Гэмт хэргийг үгүйсгэх нөхцөл байдлууд нь гадаад илрэх хэлбэр, агуулгын хувьд Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой гэмт хэргийн шинжийг агуулсан боловч ямагт нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн болон өөрсдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах зорилгын үүднээс нийгэмд ашигтай, Эрүүгийн хуульд тусгайлан заасан үйлдэл, эс үйлдэл байдаг.

Өрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн хувьд бүрэн хангаж байгаа ч үйлдэгдэх онцгой нөхцөл байдал, нийгэмд ашигтай байх сэдлээр гэмт хэргийг үгүйсгэх, эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхаар Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4

дүгээр бүлэгт заасан бөгөөд эдгээр хууль ёсны шинж Батын үйлдсэн хүнийг алах болон хүнийг алахаар завдсан дээрх гэмт хэрэгт тогтоогдоогүй байна.

6. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх, чөлөөлөх үндэслэл, журмыг тодорхойлох.

6.1. Бодлогын нөхцөлөөр Бат хэрэг хариуцах чадваргүй гэх баримтгүй тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.4 дүгээр зүйлийн 1, 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага нь гэмт хэргийн субъект бүрийн үйлдсэн гэмт хэрэг ба түүний нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна.

Мөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, түүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг бүх талаас нь харгалзан үзэх шаардлага тавигддаг.

Бодлогын нөхцөлөөр: Хохирогч Сувд хохирол нэхэмжилсэн буюу хохирол төлөгдөөгүй байх тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.5 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх нөхцөл байдалгүй гэж үзэхээр байна. Харин Батын үйлдэл нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар хэд хэдэн гэмт хэргийн шинжийг хангаж байх тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 дахь заалтад заасан “энэ хуулийн тусгай ангийн нэг бүлэгт заасан санаатай гэмт хэргийг хоёр удаа...үйлдсэн” гэх хүндрүүлэх нөхцөл байдлыг харгалзана.

Иймд Батад Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.8 дугаар зүйлийн 1, 1.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан мөн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.6 дахь заалтад тус тус зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд дээрх шалгуур, нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзэхээс гадна алахыг завдсан гэмт хэргийн хувьд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэл, журмыг баримталж, улмаар тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон хорих ялыг зохистой хэмжээгээр тогтоон оногдуулна. Улмаар Эрүүгийн ерөнхий ангийн 6.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу гэмт хэрэг тус бүрт оногдуулсан ялыг нэмж нэгтгэн нийт эдлэх ялын хэмжээг тогтооно.

6.2. Бат нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3.1 дэх заалтад зааснаар 6 жилийн хугацаагаар хорих ялаар шийтгүүлж, 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр шүүхийн шүүгчийн захирамжаар 2 жил 8 сарын хорих ялаас хугацааны өмнө тэнссэн суллагдаж, мөн хугацаагаар хяналт тогтоосон хугацаа дуусаагүй байхад дахин санаатай гэмт хэрэг үйлдсэн тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу хэд хэдэн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялыг нэмж нэгтгэх үндэслэлтэй.

Мөн Батын 2019 онд үйлдсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан дээрэмдэх гэмт хэрэг нь 2021 оны Өршөөлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт зааснаар өршөөлд хамруулахгүй нөхцөл байдалд хамаарч байх тул мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 хэсэгт зааснаар Батын хорих ялаас хугацааны өмнө суллаж хяналт тогтоосон хугацааг өршөөн хэрэгсэхгүй болгох хууль зүйн үндэслэлгүй.

Иймд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.9 дүгээр зүйлийн 1, 6.12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу Батад Эрүүгийн хуулийн 6.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар биечлэн эдлүүлэхээр тогтоосон хорих ял дээр өмнөх шийтгэх тогтоолоор оногдуулсан

хорих ялаас эдлээгүй үлдсэн 2 жил 8 сарын хорих ялыг бүгдийг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх нийт ялыг тогтооно.

6.3. Ялаас чөлөөлөх, тэнсэх, хорих ялыг хөнгөрүүлэх үндэслэл, журам хэрэглэх эсэх

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 1.1, 1.2 дахь заалт, 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл, журмаас үзэхэд эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, тэнсэх үндэслэл, журмыг хэрэглэхэд олон талт нөхцөл, шалгуурыг хангасан байхыг шаарддаг, үүний нэг нь ангиллын хувьд зөвхөн хөнгөн гэмт хэрэг байх ёстой.

Мөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5 дахь заалтад “энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг хорин жил хүртэл хугацаагаар тогтоосон ба бүх насаар хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн хүн тухайн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо нөхөн төлсөн бол тухайн зүйл, хэсэг, заалтад заасан ялын дээд хэмжээний дөрөвний гурваас хэтрүүлэхгүйгээр, ялын доод хэмжээний дөрөвний гурваас багагүй ял оногдуулах” буюу хорих ялыг хөнгөрүүлж болохыг заасан.

Гэтэл Батын үйлдсэн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.8 дугаар зүйлийн 1, 1.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.7, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан мөн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.6 дахь заалтад заасан гэмт хэрэг нь дээр дурдсан хууль зүйн шалгуур, шаардлагуудыг бүхэлд нь хангахгүй тул ялаас чөлөөлөх, тэнсэх, хорих ялыг хөнгөрүүлэх үндэслэл, журмыг хэрэглэх үндэслэлгүй байна.

6.4. Бат нь дээр дурдсан хүнийг алах болон хүнийг алахаар завдсан гэмт хэргийг үйлдэхдээ ах Доржийн эзэмшлийн портер маркийн 77-27 УБД улсын дугаартай тээврийн хэрэгслийг ашигласан байх тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого”-д хамаарах тул хөрөнгө, орлого хураах албадлагын арга хэмжээ хэрэглэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Бодлогын нөхцөлөөс үзэхэд, тухайн гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл Батын өмчлөлийнх биш байх тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар тухайн портер маркийн 77-27 УБД улсын дугаартай тээврийн хэрэгслийг хураан авах боломжгүй, түүнийг эзэмшигчид нь буцаан олгоно.

Харин Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт зааснаар тухайн тээврийн хэрэгслийн үнэ болох 5 сая төгрөгийг Батаас гаргуулж, хохирол нөхөн төлүүлэх, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд зарцуулж, илүү гарсан тохиолдолд улсын төсөвт шилжүүлэхээр шийдвэрлэнэ.

7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой нөхцөлийг хянан шийдвэрлэх:

7.1. Мөрдөн байцаалтын шатанд 77-27 УБД улсын дугаартай тээврийн хэрэгслийн эзэмшигч Доржийг иргэний хариуцагчаар татан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулсан нь үндэслэлгүй байна.

Учир нь, Батын гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан 77-27 УБД улсын дугаартай тээврийн хэрэгсэл нь Доржийн эзэмшлийнх байхаас гадна Бат нь тээврийн хэрэгслийг зориулалтын дагуу ашиглах явцдаа бусад гэм хор учруулаагүй, харин хүнийг алах санаатай гэмт хэрэг үйлдэхдээ тус тээврийн хэрэгслийг ашигласан байх тул гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг Дорж хууль ёсоор хариуцахгүй юм. Иймд Доржийг иргэний хариуцагчаар татсан мөрдөгчийн шийдвэрийг хүчингүй болгоно.

7.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 25.3 дугаар зүйлд “Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах” үндэслэл, журмыг зохицуулсан.

Тус зүйлийн 25.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Арван найман насанд хүрээгүй хүний эрх ашиг зөрчигдөх бодит үндэслэл байвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүнийг оролцуулахгүй байж болох ба өмгөөлөгчийг оролцуулна” гэж заасан тул Чимгээгээс мэдүүлэг авахдаа түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл төрөл, садангийн хүн, сурган хүмүүжүүлэгчийг оролцуулах” хууль зүйн шаардлагыг хангасан гэж ойлгохоор байна.

Өөрөөр хэлбэл, Чимгээгээс дээрх шаардлагыг ханган мэдүүлэг авах явцад түүний эрх ашиг зөрчигдөх бодит үндэслэл үүсээгүй байгаа тохиолдолд өмгөөлөгчийг заавал оролцуулах үндэслэл үүсээгүй гэж ойлгох үндэслэлтэй.

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар урьд хэлэлцүүлгийн шатанд л хэргийн прокурорт буцаах зохицуулалтай бөгөөд харин шүүх хуралдаанаас хэргийн прокурорт буцаах зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиас бүрэн халсан болно.

Хэрэв шүүх хуралдааны явцад хэргийн нөхцөл байдлыг үзэхэд хэргийн оролцогчийн эрхийг зөрчсөн, хязгаарласан нь илэрсэн тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэгт зааснаар холбогдох гомдлыг шийдвэрлэх зорилгоор шүүхээс хэргийг хянан хэлэлцэхийг нэг удаа 60 хүртэл хоногоор хойшлуулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны холбогдох зарим зөрчлийг арилгуулахаар прокурорт даалгах боломжтой.

Иймд Батын өмгөөлөгчөөс...мөрдөн байцаалтын шатанд насанд хүрээгүй хохирогч Чимгээгээс мэдүүлэг авахдаа өмгөөлөгч оролцуулаагүй учир хэргийн эцэслэн шийдвэрлэх боломжгүй. Иймд хэргийг прокурорт буцааж өгнө үү...” гэсэн хүсэлтийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй.

8. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг шийдвэрлэх:

8.1. Бодлогын нөхцөлөөс үзэхэд хохирогч Сувд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг баримтаар нэхэмжилсэн байна.

Иймд Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 505 дугаар зүйлийн 505.1 дэх хэсэгт зааснаар эмчилгээний зардлын 13,000,000 төгрөг, 508 дугаар зүйлийн 508.1 дэх хэсэгт зааснаар оршуулгын зардлын 8,000,000 төгрөг, 510 дугаар зүйлийн 510.1 дэх хэсэгт зааснаар мотоциклд учирсан хохирол 2,000,000 төгрөг нийт 23,000,000 төгрөгийг Батаас гаргуулж, хохирогч Сувдад олгоно.

8.2. Харин Сувд нь өөрөө хүнд гэмтэл авсан болон хүү Дөлгөөн нас барсны улмаас өөрийн сэтгэцэд учирсан хохирлуудыг нэхэмжилсэн боловч тухайн гэмт хэрэг нь 2023 оны 6 дугаар сарын 31-ний өдөр үйлдэгдсэн байх тул сэтгэцэд учирсан хор уршгийг үнэлэх, мөнгөн хэлбэрээр арилгахтай холбоотой шинээр батлагдсан хуулиудыг буцаан хэрэглэх үндэслэлгүй байна. Учир нь :

Манай Улсад гэмт хэргийн улмаас хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах хууль зүйн тусгайлсан зохицуулалт байгаагүй бөгөөд харин Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Шүүх шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлахдаа гэмт хэргийн улмаас хохирогчид учирсан сэтгэцийн хор уршгийг үнэлэх, мөнгөн хэлбэрээр арилгуулахтай холбоотой зохицуулалтыг шинээр хуульчилсан.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.6-д “Сэтгэцэд учирсан хор уршгийг үнэлэх, хор уршгийг мөнгөн хэлбэрээр арилгуулахтай холбоотой Шүүх шинжилгээний тухай хууль болон дагалдах бусад хуулийн зохицуулалтыг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж заасан.

Уг хуулийг дагалдуулан Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт заалт оруулж, Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаар тогтоолоор

“Хүний сэтгэцэд учирсан хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх төлбөрийн жишиг аргачлал”-ыг баталсан байна.

Мөн Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар 230, 497, 508, 511 дүгээр зүйл, түүний холбогдох хэсэгт оруулсан нэмэлт өөрчлөлт нь агуулгаараа гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хор уршгийг шаардах эрхийн үндэслэл, нөхөн төлбөрийн хэмжээ зэргийг тогтоосон байх боловч тус хуулийн 5 дугаар зүйлд “Энэ хуулийг Шүүх шинжилгээний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж заасан тул тухайн нэмэлт, өөрчлөлтийг Шүүх шинжилгээний тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.6 дахь хэсэгт заасан хугацаагаар ойлгож хэрэглэхээр байна.

Иргэний хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Хуульд зааснаас бусад тохиолдолд иргэний хууль тогтоомжийг буцаан хэрэглэхгүй” гэж заасан нь Иргэний хууль тогтоомжийг хүчин төгөлдөр болсон үеэс үүссэн эрх зүйн харилцааг зохицуулахад хэрэглэнэ гэсэн агуулгыг илэрхийлэх бөгөөд шинээр батлагдсан хууль тогтоомжид буцаан хэрэглэх нөхцөлийг тусгасан, эсхүл гэрээний үүргийн талаар илүү ашигтай журмыг тогтоосноос бусад тохиолдолд Иргэний хууль тогтоомжийг буцаан хэрэглэхгүй гэсэн ерөнхий зарчим үйлчилнэ.

Нэгэнт сэтгэцэд учирсан хор уршгийг үнэлэх, мөнгөн хэлбэрээр арилгахтай холбоотой шинээр батлагдсан хуулиудад өмнөх харилцаанд үйлчлэх талаар тусгайлан заагаагүй учир Иргэний хуульд нэмэлтээр оруулсан сэтгэцэд учирсан хор уршгийг арилгахтай холбоотой зохицуулалт нь 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ, харин 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас хохирогчийн сэтгэцэд учирсан хор уршгийг шийдвэрлэхэд буцаж үйлчлэх үндэслэлгүй байгаа болно.

БОДЛОГЫГ ДҮГНЭХ ОНООНЫ ХУВААРИЛАЛТ

№	Шалгах үндэслэл	Дүгнэх Оноо
1	Гэмт хэргийн шинжийг тодорхойлж, зүйлчлэл хийсэн хууль зүйн дүгнэлт, хууль хэрэглээ	0-9
2	Эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, хорих ял оногдуулахгүй тэнсэх, хорих ялыг хөнгөрүүлж оногдуулах үндэслэл, журам хэрэглэх талаарх дүгнэлт, хууль хэрэглээ	0-4
3	Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх, хэд хэдэн гэмт хэрэгт болон хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулах, Өршөөл үзүүлэх тухай хуулийг хэрэглэх үндэслэл, журмын талаарх дүгнэлт, хууль хэрэглээ	0-4
4	Хохирол, хор уршиг болон хөрөнгө, орлого хураах, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой нөхцөлд хийсэн дүгнэлт, хууль хэрэглээ	0-3
Нийт оноо		20 оноо